



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

20 25 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/14

Даланзадгад сум

“Эх, хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилготой “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.
3. Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

4625010040

**“ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД” ХӨТӨЛБӨР
(2025-2028)**



Нэг. Нийтлэг үндэслэл

Өмнөговь аймаг нь 2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн ам 76989 хөдөлгөөнт хүн ам 70,000 гаруй болсон бөгөөд суурин хүн амын 50,1% нь эрэгтэй, 49,9 % нь эмэгтэй эзэлж байна. Өмнөговь аймгийн хүн амын дундаж наслалт 2023 оны байдлаар 73,4 байгаа нь улсын дунджаас (71.5) 1.9 жилээр өндөр байгаа ба сүүлийн 20 жилд 7,8 жилээр өссөн байна. Дундаж наслалтын хүйсийн зөрүү 8,5 жил байгаа нь улсын дунджаас (9,2) 0,7 жилээр бага байгаа ба эрэгтэйчүүдийн дундаж наслалт 69.4, эмэгтэйчүүд 77,9 байна.

Нийт жирэмсэн үеийн хүндрэл улсын дунджаас 2003 оны байдлаар 7,5-р бага байсан бол 2023 оны байдлаар 19,8-р бага ба 2,6 дахин бага байна. Улсын хэмжээнд жирэмсний хүндрэл нэмэгдэх хандлагатай үзүүлэлт бол Өмнөговь аймгийн хэмжээнд буурч байна. Жирэмсний хүндрэлийн гол шалтгаанд жирэмсэн үеийн даралт ихсэх, манас таталтын урьдал үе (32%) тэргүүлсэн хэвээр байна. Сүүлийн жилүүдэд жирэмслэлтээс үл хамаарах эхийн эрхтэн тогтолцооны өвчин нэмэгдэж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтод эхийн эндэгдлийг 2030 онд 100,000 амьд төрөлтөд 70 болгох, Монгол Улс “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын шалгууртаа эхийн эндэгдлийн түвшнийг 2025 онд 20.0, 2030 онд 15, 2050 онд 5 болгох зорилт тавьсан ба 2023 оны байдлаар 26.4 байна.

Өмнөговь аймагт сүүлийн 6 жил (2018 оноос) эхийн эндэгдэлгүй амжилттай ажиллаж байна. 2003-2023 онд Улсын хэмжээнд нийт 716 эх эндсэн бол Өмнөговь аймагт 14 эх эндсэн байна. Монгол Улсын Засгийн газар, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн бодлого, төлөвлөлтөд эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах зорилт арга хэмжээг төлөвлөн үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд эхийн эндэгдэл 2000 оноос хойш тууштай буурсан ба 2003 онд эхийн эндэгдлийн харьцаа 110 байсан бол 2023 онд 26.4 болж 4.1 дахин буурчээ. Эхийн эндэгдлийн "Итгэмжит лавлагаа" судалгааны дүгнэлтээр 2016-2019 онд эндсэн эхийн эндэгдэлд эмийн бодисын хамаарал, архины хамаарал, архаг тамхидалт, ар гэрийн хайр халамж дутмаг, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн хүчин зүйлүүд нөлөөлөл өндөр байна гэж дүгнэсэн байдаг.

Өмнөговь аймаг 2021-2024 онд үе шаттайгаар “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд эхний 3 жилд эхийн эндэгдэл гаргаагүй, жирэмсний эрт хяналтын хувь 2021 онд 90.6 хувь байсныг 2024 онд 91.2 хувь болгон нэмэгдүүлсэн, 1000 амьд төрөлтөнд перинаталь эндэгдлийн түвшин 14.3 промилль байсныг 12.5 бууруулж ахиц гаргасан хэдий ч нөхөн үржихүйн эрүүл мэндийн хүртээмж муу, эх хүүхэд нярайн сэргийлж болох өвчлөл, эндэгдэл улс, аймгийн дунджаас өндөр байгаа нь тулгамдсан асуудал хэвээр байсаар байна.

2024 онд 5 хүртэлх насны эндэгдэл урд оноос 8 тохиолдлоор өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин улсын түвшнээс өндөр, үүнээс 83,6 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 76.6 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 76.5 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл эзэлж байна.

Өмнөговь аймгийн эх, хүүхдийн эрүүл мэндийн статистик үзүүлэлт, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2024-2028 оны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн салбарын зорилтод нийцүүлэн шинэчлэн боловсруулж, 2025-2028 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан эрсдэл, хүндрэлээс урьдчилан сэргийлж, эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулна

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулна.

Зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагын эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлж тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

Зорилт 3. Хүн амын дундах эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, хандлагыг дээшлүүлэн эрүүл зан үйл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв . Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1.1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах;

4.1.2. Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тандалт, хяналтын тогтолцоог ("Нэрийн хяналт") сайжруулах;

4.1.3. Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдэл, нөлөөлөх хүчин зүйлсийг судалгаа тогтмол хийж, нотолгоонд суурилсан хариу арга хэмжээ хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллах.

4.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.2.1. Эх барих, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлж, нутагшуулах;

4.2.2. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавих;

4.2.3. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлэх;

4.2.4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зорилтод бүлгийн эмэгтэйчүүдийг хөх, умайн хүзүүний хавдар эрт илрүүлэг шинжилгээнд хамруулах, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

4.2.5. Ураг, нярайн болон хүүхдийн эрт илрүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний нотолгоонд суурилсан үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.2.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байранд болон эмнэлэг хооронд шилжүүлэн, сэлгэн ажиллуулж чадавхжуулах, мэргэшүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

4.2.7. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад хамруулж хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх.

4.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.3.1. Оюутан залуучууд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

4.3.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн тогтвортой хангамжийг бүрдүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулах;

4.3.3. Гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчдад нөхөн үржихүйн болон хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр мэдлэг хандлагыг дээшлүүлж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд 2025-2028 онд үе шаттай хэрэгжүүлнэ

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ

- 6.1. Улсын болон орон нутгийн төсөв
- 6.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив
- 6.3. Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн

7.1. Эрүүл мэндийн байгууллагуудын эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэнээр эхийн ноцтой хүндрэл, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах.

7.2. Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, оношилгоо эмчилгээний дэвшилтэд аргыг нэвтрүүлж, хүний нөөцийг чадавхжуулснаар эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.

7.3. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэн хүсээгүй

жирэмслэлт болон үр хөндөлт буурна.

7.4. Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг эрчимтэй явуулснаар хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдэл багасна.

7.5. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэний оролцоо нэмэгдэж, эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

7.6. Хүн амын дундах нөхөн үржихүйн болон хүүхдийн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг хандлага дээшилнэ.

Найм . Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Нийгмийн бодлогын хэлтэс) хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнаж ажиллах чиг үүргийг Эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэнэ

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүр эрүүл мэндийн төвүүд аймгийн Эрүүл мэндийн газар, харьяа сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнаж, Эрүүл мэндийн газар хяналт тавьж ажиллана.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна

9.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан явцын болон хөндлөнгийн үнэлгээг жил бүр хийлгэнэ.

9.4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

Арав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, үүрэг

10.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар (Нийгмийн бодлогын хэлтэс), ажлын хэсэг

10.1.1. Аймгийн Засаг даргаар ахлуулсан Эрүүл мэндийн салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газар (Нийгмийн бодлогын хэлтэс), хөтөлбөрийн ажлын хэсэг хамтран нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажиллах;

10.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай төсвийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, батлуулах, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

10.2. Сумын Засаг даргын Тамгын газар:

10.2.1. Сумын Засаг дарга, түүний Тамгын газар, эрүүл мэндийн салбар зөвлөлөөс төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, хяналт тавих;

10.2.2. Сумын хүн амын шилжилт хөдөлгөөн, түр оршин суугаа иргэдийн бүртгэл судалгааг нарийвчлан бүрэн гарган шаардлагатай тохиолдолд шилжүүлгийг журмын дагуу хийлгэж, шуурхай бүртгүүлдэг болох, гудамж, хорооллыг хаягжуулах;

10.2.3. Эх хүүхдийн өвчлөл, ноцтой хүндрэлийн үед эмнэлэг хооронд /2, 3 дугаар шатлалын эмнэлэг/ шилжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөвлөж, эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах болон сумын эмнэлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

10.2.4. Иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааг хүргэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

10.2.5. Отор нүүдэл, ган зуд, цар тахлын үед эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй хүргэхэд бүх талаар дэмжих.

10.3. Эрүүл мэндийн байгууллагууд:

10.3.1. Хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад хяналт үнэлгээ хийх, эрүүл мэндийн байгууллагын уялдаа холбоог сайжруулахад нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган ажиллах;

10.3.2. Эх, хүүхдийн эндэгдлийн үнэлгээ дүгнэлтийг тухай бүрд хийж, алдаа зөрчлийг илрүүлж засах, сайжруулах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж үр дүнг мэдээлэх, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлж ажиллах;

10.3.3. Төрөх насны эмэгтэйчүүд, жирэмсэн эхийн нэрийн хяналтын тогтолцоог чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх;

10.3.4. Харьяаллын бус, үндсэн оршин суугаа хаяг дээрээ байдаггүй жирэмсэн эмэгтэйн мэдээллийг эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн цахим системээр илгээж,

шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагатай эргэх холбоотой ажиллах;

10.3.5. Нөхөн үржихүйн насны иргэдийг түүний хамтрагч, гэр бүлийн хамт эрт илрүүлэгт хамруулах, эрсдэлийг тогтоох, эмчлэн эрүүлжүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн мэдээлэл зөвлөгөө өгөх;

10.3.6. Алслагдсан нутагт амьдарч байгаа эсвэл өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг илрүүлж эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад шилжүүлэх, эргэх холбоотой ажиллах;

10.3.7. Жирэмсэн эмэгтэй бүрийг эрт хяналтад хамруулахад иргэд, нийгмийн ажилтан, төрийн бус байгууллага, олон нийт, сайн дурын идэвхтний дэмжлэгийг авч, хамтран ажиллах;

10.3.8. Хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг, идэвхтэй хяналт, тусламж үйлчилгээг чанартай, үр дүнтэй зохион байгуулах;

10.3.9. 5 хүртэлх насны хүүхдийн А амин дэм, 6-24 сартай хүүхэд болон жирэмсэн, хөхүүл эхийн олон найрлагат бичил тэжээл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жирэмснээс сэргийлэх арга хэрэгслээр хангах;

10.3.10. Шаардлагатай тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээ, бэлэн байдлыг хангаж ажиллах.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

Хөтөлбөрийн үр дүнг дүгнэхдээ 2024 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Эх, хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он			Хүрэх түвшин	
			Өмнөговь	2025	2026	2027 он	2028 он
1.	Эхийн эндэгдлийн тоо	тоо	0	0	0	0	0
2.	Жирэмсний эрт хяналтын хувь	хувь	91,2%	92%	93%	94%	95%
3.	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хамрагдсан хяналтын хувь	хувь	94.4%	96%	97%	98%	99%
4.	Өсвөр насны охидын төрөлтийн эзлэх хувь	хувь	4,5%	4,3%	4,1%	4%	3,8%
5.	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	тоо	17,6	16	15	14	13
6.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	тоо	19,3	19	18	17	16
7.	Перинаталь эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	тоо	12.5	12	11	10	9
8.	Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь	хувь	65.2%	68%	71%	73%	75%
9.	Үр хөндөлтийн түвшин /1000 амьд төрөлтөд/	тоо	398.9	390	385	380	375